



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/474

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалт, Аймгийн онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Хэрлэн нэгдүгээр сургуулийн барилгыг буулгасантай холбогдон "Немодо трейд" ХХК-нь 30 хувийн алдагдал хүлээж үйл ажиллагаанд нь доголдол үүсч хэвийн ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн нь ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тул аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу 15 000 000 /арван таван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сар бүр олгох дэмжлэгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Аймгийн гамшгийн эрсдлийн сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010786

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 13 өдрийн 1/474
дугаар захирамжийн хавсралт

Дэмжлэг үзүүлэх хуваарь

№	Сар	Мөнгөн дүн
1	10 сар	5000000
2	11 сар	5000000
3	12 сар	5000000
	Нийт дүн	15000000